



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ,
ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 5/401

Улаанбаатар хот

“Ажил мэргэжлийн аварга алба хаагч”,
“Тэргүүний алба хаагч”, “Хамт олон”-ыг
шагнаж, урамшуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах (код-136) журам”-ын 136.5.2 дахь хэсгийн “б”, “Тэргүүний алба хаагч, байгууллага шалгаруулах /код 133/ журам”-ын 133.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны болон Эргүүл, хамгаалалтын газрын 2022 оны “Тэргүүний хамт олон”-ыг “Батламж”, мөнгөн шагнал, мөн албаны “Ажил мэргэжлийн аварга алба хаагч”-ийг “Батламж”, цагдаа, дотоодын цэргийн бэлгэдэл бүхий “Мөнгөн” цом, мөнгөн шагнал, мөн албаны Эргүүл, хамгаалалтын газрын “Тэргүүний алба хаагч”-ийг “Батламж”, мөнгөн шагналаар тус тус шагнасугай.

2. Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл, үр бүтээл гарган 2022 оны ажлын үр дүнгээр хамт олноо хошуучлан ажилласан нэр бүхий алба хаагчдыг “Баярын бичиг”-ээр шагнасугай.


3. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны болон мөн албаны Эргүүл, хамгаалалтын газрын 2022 оны “Тэргүүний хамт олон”, мөн албаны “Ажил мэргэжлийн аварга алба хаагч”, мөн албаны Эргүүл, хамгаалалтын газрын “Тэргүүний алба хаагч”-дын нэрсийг нэгдүгээр, мөн албаны “Баярын бичиг”-ээр шагнагдсан алба хаагчдын нэрсийг хоёрдугаар, шагнал, тайлангийн хурлын үйл ажиллагаанд зарцуулах төсвийн тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Батламж, цом, мөнгөн шагнал, баярын бичигт зарцуулах зардлыг батлагдсан төсөвт багтаан, холбогдох журмын дагуу тосцож, олгохыг Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч (цагдаагийн дэд хурандаа Д.Цэцэнбилэг)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Дэд бөгөөд Захиргааны удирдлагын хэлтсийн дарга (цагдаагийн дэд хурандаа Н.Амарсанаа)-д даалгасугай.

6. Шалгарсан хамт олон, алба хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүссүгэй.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Н.ЛХАГВАСАЙХАН